



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/79

Хэрлэн сум

Спортын дэд мастер Х.Эрдэнэтунгалагт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Биндэр сумын харьяат цанын болон дугуйн спортын дэд мастер Х.Эрдэнэтунгалагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Хятад улсын Харбин хотод зохион байгуулагдах цанын Азийн их наадамд оролцоход 500,000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Үндэсний спорт болон спортын наадам, тэмцээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ





۲۵۲۶ ۲۵ ۷۷
 یسر و یسر (نم) یسر

Handwritten signature: *Handwritten signature*

Red stamp: *Handwritten signature*

Red stamp: *Handwritten signature*